

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН  
2021 ОНЫ 06 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 06 дугаар сарын 21

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 12-ны өдрийг дуустал дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн хувийн урилга, виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 341 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгосноос 278 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт, 63 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад тус тус илгээлээ.

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 35 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын Монгол Улсын визийг олгосон. *(График 1)*

1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 256 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 421 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 84 иргэний бүртгэлд хасалт хийсэн. *(График 1)*


Мөн оршин суугаа хэлбэр нь өөрчлөгдсөн 4 гадаадын иргэнд визийн ангилал солих үйлчилгээ үзүүлж, уригч 9 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу гадаадын 9 иргэний виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгосон байна.

Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 36 гадаадын иргэнийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн 56 иргэний бүртгэлд хасалт хийж, Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн, мөн визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэнээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 10 иргэний визийн хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. *(График 1)*

Энэ сарын тоон үзүүлэлтийг 2020 оны 06 дугаар сарын тоон үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 3.4 дахин, оршин суух зөвшөөрөл олголт 12.2 дахин, түр ирэгчийн бүртгэл 1.9 дахин өсөж, виз олголт 37.5 хувь, түр ирэгчийн хасалт 20.0 хувь, оршин суух зөвшөөрлийн сунгалт 36.9 хувь, оршин суух зөвшөөрлийн хасалт 97.5 хувь, визийн хугацааны 30 хүртэлх хоногийн сунгалт 95.8 хувиар тус тус буурчээ.

Монгол Улсад оршин суух цахим үнэмлэхийг 454 ширхэг шинээр хэвлэн, 369 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 19 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

График 1



Гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 694 иргэн (1800-1882 дугаарын утсаар 484, биечлэн 21, автомат хариулагчаар 42, имэйлээр 2, фэйсбоок хуудасны чатботоор 145)-д зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан ба код мессеж үйлчилгээг 89 иргэнд илгээсэн. Мөн KGB шуудан үйлчилгээнд 1 оршин суух үнэмлэх, 1 тодорхойлолт илгээжээ.

Тайлант хугацаанд нийт 15 аж ахуйн нэгж, байгууллагын 25 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eVisa.mn)-аар хүлээн авч, шийдвэрлэсэн байна. Үүнд:

- “Т” ангиллын 7 аж ахуйн нэгж, байгууллагын 8 гадаадын иргэн,
- “HG” ангиллын 5 аж ахуйн нэгж, байгууллагын 8 гадаадын иргэн,
- “S” ангиллын 1 аж ахуйн нэгж, байгууллагын 1 гадаадын иргэн,
- хувийн хэргээр оршин суугч 1 гадаадын иргэн,
- түр ирэгчээр визийн байх хугацааг сунгуулах 3 гадаадын иргэний хүсэлт,
- визийн зөвшөөрөл хүссэн 2 аж ахуйн нэгж, байгууллагын 4 гадаадын иргэний хүсэлт (“B” ангиллын 3, “Т” ангиллын 1 гадаадын иргэнд нэг болон хоёр удаагийн орох)-ийг тус тус хянан шийдвэрлэсэн.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Монгол Улсын харьяат болох, гарах, сэргээн тогтоолгох:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 152 дугаар, 06 дугаар сарын 10-ны өдрийн 162, 163 дугаар зарлигаар гадаад улсын 3 иргэн (Хятад Улсын 2, Орос Улсын 1) Монгол Улсын харьяат болсон.


Тайлант хугацаанд Монгол Улсын харьяатаас гарсан болон иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон иргэний тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гараагүй байна.

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан 40 иргэн, Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авсан.

Дээрх хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 2 иргэнийг шинээр бүртгэж, бүртгэлийг мэдээллийн санд оруулсан. (График 2)

06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор гадаадын иргэний нэгдсэн бүртгэлийн санд 51 улсын 3848 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна.

График 2



1.2.2. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаатай холбоотой хүсэлт гаргасан 1 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтэд санал авахаар баримт бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлжээ.

2021 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 87 төрийн бус байгууллага бүртгэлтэй байна.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Тайлант хугацаанд 1 удаагийн төлөвлөгөөт, 4 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 6 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 36 иргэнийг хамруулснаас гадаадын 5 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 500.000 төгрөг (*Таван зуун мянган*)-ийн шийтгэл оногдуулж, улсын төсөвт төвлөрүүлжээ.

1.3.2. Хориг арга хэмжээ:


Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4, 37.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн 2 улсын 2 иргэн (*Казакстан Улсын 1,*

Нидерланд Улсын 1)-ийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар албадан гаргасан. (График 3)

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 2 улсын 2 иргэн (Казакстан Улсын 1, Хятад Улсын 1)-ийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүллээ. (График 3)

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан үндэслэлээр Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 1 удаагийн захирамжаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх Гадаадын иргэнийг саатуулах байранд 1 улсын 1 иргэн (Хятад Улсын 1)-ийг саатуулсан.

График 3



2021 оны 06 дугаар сарын тоон үзүүлэлтийг 2020 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 82.1 хувиар буурч, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд, зөрчил гаргасан уригч иргэн бүртгэгдээгүй байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тус байгууллагад холбогдох арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланд байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн, 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, мөн өдөр цахимаар болон 01/862 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Байгууллагын үйл ажиллагааны 05 дугаар сарын тайланг нэгтгэн боловсруулж, тоон мэдээг инфографик хэлбэрээр 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/806 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Байгууллагын 2021 оны 05 дугаар сарын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох хугацаанд нь Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон

нутгийн хэлтэст хүргүүлж, 06 дугаар сарын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 05-ны өдөр нь батлуулж, зохион байгуулалтын нэгжийн дарга нарт цахимаар хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

#### 2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц:

Тулгар төрийн 2230, Их Монгол Улсын 815, Ардын хувьсгалын 100 жилийн ойн баярыг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт гарган, үр бүтээлтэй ажилласан 1 албан хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 94 дүгээр зарлигаар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор, 5 албан хаагч Хууль зүй, дотоод хэргийн сайдын 06 дугаар сарын 11-ний өдрийн А/131 дүгээр тушаалаар “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгээр, 18 албан хаагч Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр тус тус шагнагдлаа.

#### 2.1.3. Олон нийт, мэдээ, мэдээлэл:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар олон нийтэд таниулан сурталчлах ажлын хүрээнд байгууллагын дарга Н.Ууганбаяр 06 дугаар сарын 04-ний өдөр ТВ9 телевизийн “Энэ өдөр” мэдээллийн хөтөлбөрт 06 дугаар сарын 08-ны өдөр англи хэлээр мэдээ, мэдээллээ бэлтгэн хүргэдэг C Channel Mongolia телевизийн “Онцлох ярилцлага” нэвтрүүлэгт тус тус оролцож, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө.

#### 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

##### 2.2.1. Хууль, эрх зүй:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ын төсөлд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны “Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал батлах тухай” А/147 дугаар тушаалын дагуу нөлөөллийн шинжилгээг хийж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

##### 2.2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ч.Алтансүх, Монгол улсад байнга оршин суугаа Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Иргэдийн зөвлөлийн тэргүүнтэй 06 дугаар сарын 03-ны өдөр Тайпэйн Худалдаа, Эдийн Засгийн Улаанбаатар дахь Төлөөлөгчийн газрын хоёрдугаар нарийн бичгийн даргатай тус тус уулзаж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт, түүнийг даган гарах журмын талаар товч мэдээлэл солилцлоо.

Мөн 06 дугаар сарын 11-ний өдөр Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны атташе болон албаны бусад хүнийг хүлээн авч уулзав.

Шинэчлэн батлагдсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн танилцуулга мэдээллийг гадаад улсаас Монгол Улсад суугаа холбогдох төлөөлөгчийн газруудад цахимаар хүргүүлсэн.

Бусад орны ижил чиг үүргийн байгууллагуудын шинэ мэдээ, мэдээллийг “7 хоногийн тойм” нэрээр бэлтгэн долоо хоног тутам Хууль зүй, дотоод хэргийн

яамны Олон улсын гэрээ, хамтын ажиллагааны газарт цахим хэлбэрээр хүргүүлэн ажиллаж байна.

#### 2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

##### 2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Байгууллагад ирүүлсэн нийт 439 албан бичиг (*харуутай 83*)-ийг хүлээн авч, 254 албан бичгийг гадагш илгээсэн.

##### 2.4.2. Өргөдөл, гомдлын чиглэлээр:

2021 оны эхний хагас жилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан хаагчдаас нийт 9 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 4 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 5 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. Хуулийн хугацаа хэтрүүлсэн өргөдөл байхгүй.

#### 2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

##### 2.5.1: Программ хангамж:

“Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох цахим систем хөгжүүлэх” 01/07-05 дугаартай гэрээний дагуу Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем /RNSF/-ийг 06 дугаар сарын 01-ний өдрөөс ашиглалтад оруулж, мөн сарын 10-ны өдрийн байдлаар нийт 100,444 гадаадын иргэнд регистрийн дугаар олгосон.

Гадаадын иргэн, харьяатын газрын “Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох” /RNSF/ программ болон Хил хамгаалах ерөнхий газрын “Гадаадын иргэний био мэдээллийн бүртгэлийн систем”-ийн хооронд мэдээлэл харилцан солилцох ажил явагдаж байна.

“Гадаад иргэнийг бүртгэх бүртгэлийн аппликейшн хөгжүүлэх” 01/07-06 дугаартай гэрээний дагуу Гадаадын иргэнийг 48 цагийн дотор гар утаснаас бүртгэх бүртгэлийн аппликэйшнийг хөгжүүлж, 06 дугаар сарын 04-ний өдөр эхний хувилбарыг нэвтрүүлэв.

“Визийн мэдээллийн нэгдсэн сан” төсөл 2021 оны 05 дугаар сараас эхлэн тус байгууллагад хэрэгжиж, сангийн хөгжүүлэгч шалгаруулах тендерт шалгарсан Интерактив ХХК 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс системийн хөгжүүлэлтийг эхлэн 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар цахим визийн eVisa.mn сайтаар дамжуулан визийн хүсэлтийг хүлээн авах эхний хувилбарыг ажиллагаанд орууллаа.

Мөн байгууллагын цахим хуудсыг шинэчлэн, НҮБ-ын 5 хэл дээр хөгжүүлэлтийг хийлээ.

#### 2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

##### 2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

2021 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 3,917.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 2,680.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу өр, авлагагүй, хэмнэлттэйгээр, зохих журамд нийцүүлэн анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Байгууллагын даргын Б/131, Б/132, Б/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн холбогдох албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүллээ.

Худалдан авах ажиллагааны 05 дугаар сарын явцын тайланг 01/790 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн ба Голден Хоул ХХК-аас 126 лицензийн эрхийг хүлээн авч, гэрээ дүгнэсэн акт үйлдэв.

### 2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоол, 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар тэмдэгтийн хураамж, хүү торгуулийн орлого нийт 406.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР